

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2019 оны 02-р сарын 15

Тендер шалгаруулалтын нэр: “ЭШ-10/70 экскаваторын сэлбэг нийлүүлэх”

Тендер шалгаруулалтын дугаар: МРЦМ/201901364

“Монголросцветмет” ХХК эрх бүхий тендерт оролцогчдоос **“ЭШ-10/70 экскаваторын сэлбэг нийлүүлэх”** тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү барааны тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэгүй авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50'000.00 /тавин мянган/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: *Сүүлийн 2017, 2018 оны аль нэгд гүйцэтгэсэн борлуулалтын хэмжээ тендерт ирүүлсэн үнийн саналын мөнгөн дүнгийн 100%-иас багагүй байна*

Тусгай зөвшөөрөл шаардлагатай эсэх: **Шаардлагатай**

Тендерийн хамт **1 089 000** төгрөгөөс багагүй үнийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2019 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 10:00 цагаас** өмнө www.tender.gov.mn хаягаар ирүүлэх ба **мөн өдрийн 10:05 цагт** цахим системээр нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: **Зөвшөөрөхгүй.**

Дотоодын давуу эрх тооцох эсэх. **Тооцохгүй.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно:

Улаанбаатар хот, БЗД 22-р хороо, Энхтайваны өргөн чөлөө – 98, 409 тоот өрөө, утас: 450060 + 188

“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ХХК